



**ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Номт 1 дүгээр баг, Зуунмод сум, Төв аймаг, 41111  
Утас: 70273623, Цахим шууданг: tuv\_zdtg@tov.gov.mn

2026. 03.31 № 02/445

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

СУМЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

*ГХУСАЗ-ын нэг хэсэг хэргийн дарга болон хэрэгжүүлэгчид хамтран зохион байгуулсан тэдгээрийг зургуулаж амжиллаа.*  
2026. 04. 02. *Шанз*

Хэлэлцүүлэг хийх тухай

Аймгийн Цагдаагийн газрын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 5540 дугаар мэдэгдэлд "Аймгийн хэмжээнд 2025 онд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээгээр согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоо 317 болж өмнөх оноос 99 буюу 45.4 хувиар өссөн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг Зуунмод, Заамар, Сэргэлэн, Жаргалант, Баянчандмань, Эрдэнэ сумдад хамгийн олон үйлдэгдэж, нийт гэмт хэргийн 33 хувийг эзэлж байна. Мөн өмнөх оноос өссөн гэмт хэрэг, зөрчлийн дотроос хүний амьд явах эрхийн эсрэг болон хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нь архи дан согтуурсантай холбоотой байна.

Архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, согтууруулах ундааны хэрэглээ, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, бууруулах, урьдчилан сэргийлэхэд хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх зорилгоор "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар үүрэг хүлээгч байгууллагуудын нээлттэй хэлэлцүүлэг"-ийг 4 дүгээр сард зохион байгуулахаар шийдвэрлээд байна.

Хэлэлцүүлэг 2 үе шаттай явагдах бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 02-03-ний хооронд сумын Засаг даргын Тамгын газарт, 2026 оны 04 дүгээр сарын 08-нд аймгийн ЗДТГ-т зохион байгуулна.

Суманд зохион байгуулах хэлэлцүүлэгт Архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн сумын ГХУСАЗЗ, сумын удирдлагууд болон сумын ИТХ-ын төлөөлөгч, төрийн байгууллагын дарга нар, цагдаагийн төлөөлөгч, ажилтан, төрийн албан хаагчид, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулан зохион байгуулна. Хэлэлцүүлгийн удирдамжийг хүргүүлэв.

Хэлэлцүүлгээс гарсан санал хүсэлт болон судалгааг нэгтгэсэн тайлангаа 04 дүгээр сарын 08-ны дотор аймгийн ЗДТГ-т ирүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг 99019718, 88890198 утсаар авна уу.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА

С.ЦОГБАЯР

412602022E

БАТЛАВ: ..... ДАРГА .....

**АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТАЛААРХ НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

2026.04...

**Зорилго:** Аймаг, сумын хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны эргэлтэнд хяналт тавих, согтууруулах ундааны хэрэглээ, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх

**Зохион байгуулах хугацаа, газар:** 2026.04....-ны өдрийн .... цагаас сумын ЗДТГ-ын ..... танхимд

**Зохион байгуулагч:** Сумын Засаг дарга, сумын ГХУСАЗЗ, сумын ЗДТГ

**Оролцогчид:**

Сумын ИТХ-ын дарга  
Сумын ИТХ-ын Хүний эрх, хууль хяналтын хороо,  
Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн төлөөлөл  
Сумын ГХУСАЗЗ  
Сумын Засаг дарга  
Сумын Засаг даргын орлогч  
Сумын ЗДТГ-ын дарга, холбогдох мэргэжилтнүүд  
Багийн Засаг дарга нар  
Цагдаагийн төлөөлөгч, цагдаа  
Төрийн байгууллагууд  
Тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн төлөөлөл  
ТББ, судлаачийн төлөөлөл  
Иргэдийн төлөөлөл

Хэлэлцүүлгийн хөтөлбөрийн төсөл:

дд	СЭДЭВ АГУУЛГА	ХУГАЦАА	ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН
1	Хэлэлцүүлгийг нээх	5 мин	Сумын ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗЗ-ийн дарга .....
2	Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл олгох журам, цагийн хязгаар тогтоосон аймгийн шийдвэр, Хуулийн хэрэгжилтийг хангах талаар сумаас	5-10 мин	Сумын ГХУСАЗЗ Сумын ЗДТГ

	төлөвлөн хэрэгжүүлж байгаа ажлын тухай		
3	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчил, тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанд тавьсан хяналт шалгалтын тухай	5-10 мин	Цагдаагийн төлөөлөгч
4	Согтууруулах ундааны хэрэглээ, эрүүл мэндийн хор нөлөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай	5-10 мин	ЭМТ
3	Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААН-дээс хуулийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулж байгаа ажлын	5 мин	Сумын ЗДТГ ААН-ийн төлөөлөл
4	+.....		
5	Асуулт хариулт, ярилцлага	-	Оролцогчид
6	Хуулийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар санал асуулга, судалгаа авах	Хэлцүүлгийн явцад	Сумын ЗДТГ
7	Хэлэлцүүлгийг дүгнэж, үүрэг чиглэл өгөх	5 мин	Сумын .....

..oOo..

## САНАЛ АСУУЛГА

Архидан согтуурахтай тэмцэх, хяналт тавих, согтууруулах ундааны хэрэглээ, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал авч байна.

Нэг: Архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавих талаар цаашид ямар арга хэмжээ авах талаар таны санал .....

.....

.....

.....

Хоёр: Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл, цагийн хянггаарын талаар таны санал.....

.....

.....

.....

Гурав: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар таны санал.....

.....

.....

.....

Дөрөв: Архидан согтуурахтай тэмцэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын талаар таны санал: .....

.....

.....

---

САНАЛ АСУУЛГА

№	Санал асуулга	Иргэд, ААН, төрийн албан хаагчаас гарсан санал	Санал асуулга авсан иргэд, ААН, төрийн албан хаагчийн тоо
1	Нэг. Архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хэрэглээнд хяналт тавих талаар цаашид ямар арга хэмжээ авах талаар таны санал	- Архины хор хөнөөлийн талаар сургалт сурталчилгаа, шторк бэлтгэж цахим орчноор мэдээлэл хүргэх	12
2	Хоёр:Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл, цагийн хязгаарын талаар таны санал	-Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл, цагийн хязгаарыг оройны 22:00 цаг хүртэл	18
3	Гурав: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар таны санал	-Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо хураамжийг нэмэгдүүлэх, зөвшөөрлийг хүн амд ногдох стандартаар олгох - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж аян зохион байгуулах	3
4	Дөрөв:Архидан согтуурахтай тэмцэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замын талаар таны санал:	-Согтууруулах ундаа хэрэглэсэн үйлчлүүлэгч зүй бус авирлаж, хараал хэлж, эд хөрөнгө эвдэж сүйтгэвэл түүнийг сумын цагдаад мэдэгдэж, эрүүлжүүлэхэд хийх, гаргасан зөрчилд нь заагдсан арга хэмжээ авах - Тухайн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдэд Засаг даргын захирамжаар долоо хоногийн нэг өдрийг архи худалдаалдаггүй өдөр болгох	8